



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 600

Улаанбаатар хот

“Завхан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн
2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт,
зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Завхан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Компанийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн 2020 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх захирал М.Болдод даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ш.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0001-57

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 1-ны өдрийн
600 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"ЗАВХАН АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2020 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

Д.д	Үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2018 оны гүйцэтгэл	2019 он		2020 оны төлөвлөгөөн ий төсөл	Харьцуулалт	
				Төлөвлөгөө	ХБГ		Хувиар (2020төл/20 19ХБГ/	Дүнгээр (2020төл- 2019ХБГ)
1	Нийт орлого	мян.төг	1,088,576.3	999,096.7	588,709.7	869,267.0	147.7	280,557.3
	Үүнээс: Улсын чанартай ЗЗА	мян.төг	557,239.2	673,254.7	546,873.5	734,663.5	134.3	187,790.0
	Бусад	мян.төг	531,337.1	325,842.0	41,836.2	134,603.5	321.7	92,767.3
2	Нийт зардал	мян.төг	1,065,579.5	983,204.5	583,709.5	855,250.0	146.5	271,540.5
	Удирдлагын зардалд	мян.төг	139,369.1	146,618.7	146,618.7	157,990.9	107.8	11,372.2
3	Татварын өмнөх ашиг	мян.төг	22,996.8	15,892.2	5,000.2	14,017.0	280.3	9,016.8
4	Цэвэр ашиг/ алдагдал/	мян.төг	20,697.1	14,303.0	4,500.2	12,615.3	28.0	901.7
5	Төсвийн төлбөрт	мян.төг	203,242.5	130,752.9	105,967.7	156,468.0	147.7	50,500.3
6	Төрийн өмчийн ноогдол ашиг	мян.төг	2,483.7	2,860.6	575.8	1,513.8	262.9	938.0
7	Нийт авлага	мян.төг	298,074.1	56,782.6	108,700.0	98,432.0	90.6	(10,268.0)
8	Нийт өглөг	мян.төг	392,641.7	331,876.8	331,876.8	328,514.3	99.0	(3,362.5)
9	Үүнээс: богино хугацаат	мян.төг	101,281.7	40,516.6	40,516.6	37,154.3	91.7	(3,362.3)
	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төг	0.97	0.98	0.99	0.98	1.0	(0.0)
10	Хөрөнгө оруулалт	мян.төг	15,000.0	21,800.0	21,800.0	46,500.0	213.3	24,700.0
11	Ажиллагсдын тоо	хүн	48	48	38	38	100.0	-
12	Цалингийн сан		221,749.4	260,452.0	240,452.0	265,452.0	110.4	25,000.0
13	Нэг ажилтаны дундаж цалин	мян.төг	461.90	673.10	781.30	852.00	109.0	70.7

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
600 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**"ЗАВХАН АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2020 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Тухайн жилд худалдан авах хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Төлөвлөгөө		
			Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Өөрөө буулгагч машин /25 тн/	мян.төг	1	44,600.0	44,600.0
2	Бетон зуурагч	мян.төг	1	1,000.0	1,000.0
3	Цахилгаан үүсгүүр	мян.төг	1	600.0	600.0
4	Гагнуурын аппарат 220	мян.төг	1	300.0	300.0
5	Нийт дүн	мян.төг			46,500.0